

**“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН БАРУУН ТТӨВ
ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН ТОДОРХОЙЛОЛТ**

2020 оны 11. сарын 31.


1. Зураг төслийн захиалагч, объектын байршил: № 14-р хороо “Кристал ог”
ХХК-ийн чиймжийн орчин сүүрүүн гадна чажилсан дэхдэни.
2. Зураг төслийн гүйцэтгэгч: “Тэмиш” ХХК
3. Зураг төслийн дугаар, нэр: ТМ-04/2020
4. Зураг төсөлд хийсэн тодруулга:

A. Ойртож буй шугам, тоноглол

Тандын том бүр. кабелийн тусим болон ХТЛ-ийн барилгын тусим:

- ① ХТЛ-593-с ХТЛ-206 хооронд 10кв кабель ХТЛ-иа барилгын сурьбын орсон кабельтэй огтуулсан
- ② ХТЛ-206-с ХТЛ-206
- ③ ХТЛ-593-с 103 байрийн 0.4кв кабельтэй огтуулсан. Энэ
- ④ ХТЛ-206-с ХТЛ-210 10кв дли. кабельтэй огтуулсан туссэй ойртож.

B. Огтлолцож буй шугам, тоноглол



Ажил эхлэх үед БТТ-р хяналт тавиулах, газар дээр нь кабелийн тандалд хийлгэх шаардлагатай

Жич: Бусад иргэн, хуулийн этгээдийн шугам сүлжээг тухайн эзэмшигчтэй зөвшилцэх шаардлагатай.

Тодруулга хийсэн: Мэдээллийн сангийн инженер: Сангуул / Д.Гантулга/

БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Д.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/00244/20

2020 оны 02 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүснэгтийн дугаар:	20-52-000111
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР Төрийн байгууллага, РД: 2117401
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Баянгол 17-р хороо, УБ БГД 17-р хороо 27-р байр
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Үйлчилгээтэй орон сууцны барилга
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) НЭД-ЫН 2019.05.29-НЫ А/514 тоот захирамж 2) ХБХГ-ЫН 2020.01.28-НЫ 07/330 тоот албан бичиг
1.6	Техникийн нөхцөлийн ангилаал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	630 кВА (тоогоор) /Зургаан зуун гуч/ (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	110/10/6 кВ-ын Умард дэд станц, ХБ-13-с 10 кВ-ын 4xТП-8 А,Б фидерийн ХТП-206-н 10 кВ талын I ба II секцэнд шинээр ачаалал таслагч бүхий ячейк тоноглож кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөө /ХТП/-г тэжээх. Орон сууцны хэсгийг: Шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцээс кабель шугам татаж тэжээх. Үйлчилгээний хэсгийг: Шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ талаас кабель шугам татаж орон сууны хэсгээс тусад нь тэжээх.
-----	---

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
3.2	Айл өрхөд 1 фазын баталгаат бүрэн электрон тоолуур суурилуулах.
3.3	Орон сууцны нийтийн эзэмшлийн хэрэглээг тоолдог баталгаат бүрэн электрон тоолуур суурилуулах.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*630 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шаталтай трансформатор бүхий дэд өртөөг өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
4.2	Шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талын хуваарилах хуваарилах байгууламж нь 10-аас доошгүй ячейк суурилуулсан байх.
4.3	УБЦС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг

	харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.4	ХТП-206-н барилгыг батлагдсан зургийн дагуу шинэчлэн өргөтгэх
4.5	Эрчим хүчний сайдын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 276 тоот тушаалын дагуу энэхүү техникийн нөхцөлөөр 2020 оны 03 сарын 01-нээс хойш сүлжээнд холбогдохыг анхаарна уу.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:


- 5.1 Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцэн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
- 5.2 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчийт хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхиноос үзэх.
- 5.3 Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагч, богино залгааны гэмтэл заагч датчийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
- 5.4 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
- 5.5 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.13-д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.
- 5.6 Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтооолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
- 5.7 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 -д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
- 5.8 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээг байгуулах.
- 5.9 Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.
- 5.10 Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
- 5.11 "Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурvas дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.12 Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.13 Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиуулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 5.14 Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.

5.15 Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:


6.1 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг

 Б.Азаяа

 Т.Мөнхболд

 Н.Пунцагноров

Боловсруулсан:

 Б.Батсүрэн



УСУГ-ын Техникийн нэхцэл олгос комиссын
2020 оны 01-р сарын 29-ний өдрийн хурлын
11 тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НЭХЦЭЛ № 11120

1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	"Кристал инженеринг констракшн" ХХК, үйлчилгээтэй 140 айлын орон сууцны 12 давхар барилга, БГД 17-р хороо, АШХангахгүй о/сууцны 27-р байрыг буулгаж барих
2	Нийт усны хэрэглээ:	Цэвэр усны – 65,58 м ³ /хон Галын усны – 10,0 л/с Бохир усны – 65,58 м ³ /хон
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	ОСЧААУГ-ын 03/2020 тоот техникийн тодруулгын дагуу Баруун түгээх төв, ХҮТ-12-ын УДДТ-102-ын дараах шугамнаас холболттой хуучин барилгын шугамыг өргөтгэж холбох, ажлын зургийн явцад зөвшилцэх
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	ОСЧААУГ-ын 03/2020 тоот техникийн тодруулгын дагуу Баруун түгээх төв, ХҮТ-12-ын харьяа хуучин барилгын шугамын худагт холбох, ажлын зургийн явцад зөвшилцэх
5	Нэмэлт нэхцэл	Бусад шаардлага: <ul style="list-style-type: none"> ➢ Ус хангамж, ариутгах татуургын системийн утаалга, шахалт, туршилт тохицуулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах. Ус нөөцлүүр /резервуар/ төлевлэж угсралт ➢ Барилгын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний холбох цэгийг өөрчлөх тохиолдолд хүсэлт тавьж хянуулан, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. ➢ Холбогдох Хууль, БНБД, стандартыг мөрдөх ➢ Гадна шугамын ажлын зургийг ХБХГ-тай зөвшилцэх ➢ Стандартын дагуу тос баригч сууринтууллах
6	Тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Барилгыг "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн дагуу цэвэр усны шугамын тэнхлэгээс 5 м, бохир усны шугамын тэнхлэгээс 6 метр зайд барих 2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.10 –ын дагуу хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нэхцэл олгосон тохиолдолд батлагдсан ажлын зураг, төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах. 3. Борооны ус зайлцуулах шугам сүлжээг тусад нь төлөвлөх, борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх. 4. Цэвэр, бохир усны шугамын угсралт, шахалт туршилт, холболтын ажлын явцад ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө. Гадна ЦУХ-т галын гидрант сууринтуулах 5. Төвийн болон хэрэглэгчийн цэвэр, бохир усны худаг, шугам сүлжээн дээр болон хамгаалалтын бүсэд зам талбай, авто зогсоол, барилгын довжоо, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийх боломжыг бүрдүүлэх, засварын дараах нөхөн сэргээлтийн ажлыг өөрсдөө хариуцах 6. Техникийн нэхцлийн хүчинтэй хугацаа 2 жил.
7	Объект барих дээд газрын шийдвэр:	<ul style="list-style-type: none"> ➢ НЗД-ын 2019-05-29-ний А/514 дугаартай захиралж ➢ ГБМЗХ2019/04-040 тоот архитектур төл-тийн даалгавар
8	Хэрэглэгчийн нэр, утас:	"Кристал инженеринг констракшн" ХХК, Утас: 99105116



ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ

БАТЛАВ	
УГДААНДАТАР ХОТ	
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СУЛЖЭЭ	
ХХК-ИЙН ГҮЙЦЭГЭХ ЗАХИРАЛ	
Ч.ЗОЛБАЯР	
2020 оны 02 сарын 09	

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ


Дугаар: TH-B32/2020

2020/01/29

- Захиалагч
байгууллага:** КРИСТАЛ ИНЖЕНЕРИНГ КОНСТРАКШН ХХК
- Хэрэглэгчийн нэр:** Б.ЭРДЭНЭБИЛЭГ
- Харилцах утас:** 99105116
- 1. Байршил:** БГД-н 17-р хорооны 27-р байрны суурин дээр.
- 2. Зориулалт:** Үйлчилгээтэй орон сууцны барилга
- 3. Холбооны хэрэгцээ:** /урьдчилсан тооцоогоор/
Телефон тоо (ширхэгээр) 50 ш
- 4. Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ТӨК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
- 5. Техникийн үндсэн нөхцөл**
- 5.1. ХШ 612-ний хүрээний S-C 12-10 худгаас барилга хүртэл 110 мм-н 2 яндантай сувагчлал хийх ба шинээр хийх сувагчлалыг 1,0-1,2 метрийн гунд сууринуулна.
 - 5.2. Сувагчлал хооронд худаг сууринуулах зайд хэмжээг 120 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба эргэлт болон барилгын оролтонд зайлшгүй стандартын худаг сууринуулна.
 - 5.3. ХШ 612-ний 10-р зуутын 6-10-р аравтыг оролтын худгаас салаалан авч одоо байгаа сувагчлал болон шинээр хийсэн сувагчлалаар татан барилгад оруулж төгсгелийн төхөөрөмжид холбоно
 - 5.4. Уг техникийн нөхцөлд зориулж гр 11/7-н 84-87-р хосыг эхний ээлжинд нөөцлөв.
 - 5.5. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.
- 6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:**
- 6.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
 - 6.2. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
 - 6.3. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон сууринуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.
- 7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**
- 7.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ны УБ Хотын сүлжээний газрын Бүртгэл төлөвлөлтийн тасгаар (Утас: 70112399) хянуулан баталгааг өвсэн байх.
 - 7.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харьялагдах тухайн тасгийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актаанд хавсаргах.
 - 7.3. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ УБ Хотын сүлжээний


- газрын ерөнхий инженерээс албан ёсны мэдэгдлийг авч тухайн харьялагдах тасгийн ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэн.
- 7.4. Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.
- 7.5. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангулсан байх.
- 7.6. Хэрэглэгч холбох нөхцлийг бурдуулэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн, техникийн актны хамт гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна. Шинээр хийсэн сувагчлалын трассыг Нийслэлийн мэдээллийн санд оруулсан тодорхойлолт бичиг болон СД-т техникийн актны хамт УБ Хотын сүлжээний газарт хүлээлгэн өгнө.
8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:
- Шинээр хийгдсэн холбооны худаг сув агчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:
- 8.1. Танай эзэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.
- 8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
- 8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.
9. Техникийн нөхцлийг КРИСТАЛ ИНЖЕНЕРИНГ КОНСТРАКШН ХХК-н гүйцэтгэх захирлын 2020 оны 01-р сарын 23-ний өдрийн 0123/07 тоот албан бичгийг үндэслэн олгов.
10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу УБ Хотын сүлжээний газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.
11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга



Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер



Н.НАРАНБААТАР

Боловсруулсан :
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер



Д.БАЛМАА